

**“НОГООН АЛТ” БЭЛЧЭЭРИЙН ЭКОСИСТЕМИЙН УДИРДЛАГА
ХӨТӨЛБӨРИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

2009 оны жилийн эцсийн байдлаар

№	Хөтөлбөрийн агуулга		Гүйцэтгэл				
1	Хөтөлбөрийн нэр		“Ногоон алт” бэлчээрийн экосистемийн удирдлага хөтөлбөр				
2	Санхүүжүүлэгч байгууллага		Швейцарийн хөгжлийн агентлаг				
3	Хөтөлбөр хэрэгжүүлж буй хугацаа		2004 – 2008 он				
5	Хөтөлбөрийн зорилго		“Бэлчээрийг үр ашигтай, зохистой ашиглах замаар ядуу болон эмзэг бүлгийн малчдын бие даасан байдлыг бэхжүүлж, амьжиргааны түвшинг дээшлүүлэх”-д оршино.				
6	Хөтөлбөрийн зорилтууд		<p>1.Бэлчээр сайжруулах, ногоон тэжээл бэлтгэх зохистой технологийг туршин баталгаажуулж малчдын амьдралд нэвтрүүлэх.</p> <p>2.Сонгосон газруудад малчид, орон нутгийн удирдлага, бусад оролцогчдыг хамруулан бэлчээрийн хамтын удирдлагын аргыг боловсруулах, хэрэгжүүлэх</p> <p>3.Бэлчээр сайжруулах, бэлчээрийн хамтын удирдлагын арга боловсруулах, хэрэгжүүлэх хууль эрх зүйн таатай орчин бүрдүүлэх</p>				
8	Зардал 2004-2008	Төсөв /нийт шаардагдах зардал/	4,5 сая.CHF				
		Гүйцэтгэл	4,3 сая. CHF				
		Үүнд:	Зардлын нэр	Үнийн дүн /CHF/ Төсөв зарцуулалт			
			1.Бэлчээр сайжруулах технологийг боловсронгуй болгох	1538,0мян.chf	1071.4мян.chf		
			2.Бэлчээрийн хамтын менежмент	1665,4мян.chf	2014,3мян.chf		
			3.Хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох	56,9 мян.chf	36,6мян.chf		
		4.Төлөвлөлт з/б чадавхийг бэхжүүлэх	543,6 мян.chf	355,5мян.chf			
		5.Төслийн нэгжсийн удирдлагын зардал	885,0мян.chf	826,3 мян.chf			
		6.Нийт:	4500,0мян.chf	4304,1мян.chf 96.6%			
Санхүүгийн талаар:							
9	Хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ	Биелэлт % 81,2%	Дүн	83,0	83,3	75.0	83,5
		II шатны зорилт, арга хэмжээ	4	1	1	1	1
10	Хөтөлбөрийн хэрэгжилт		2009 оны хэрэгжилт-81.2%				
	Үр дүн 1.1: Бэлчээр сайжруулах, нөхөн сэргээх, ногоон тэжээл тариалах зохистой технологи боловсруулах:		Үр дүн 1.1: Бэлчээр сайжруулах зохистой технологийг боловсруулах 9 төрлийн туршилтуудыг экологийн өөр өөр бүсүүдэд явуулжээ. Хөтөлбөр нь: Ургамлын үрийн аж ахуйн систем нурж, улсын хэмжээнд тэжээлийн нэг болон олон наст ургамлын үрийн нөөцгүй болсон				

Хэрэгжилт-77,8%

өнөөгийн нөхцөлд үрийн аж ахуйг сэргээж, үрийн нөөц бүрдүүлэх ажлыг эхлүүлж, тэжээл үйлдвэрлэлийн ажлуудыг хийж гүйцэтгэжээ. Тэжээл үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх зорилгоор нэг болон олон наст ургамлын 20 гаруй тн үр импортоор, 140 тн үр дотоодоос тус тус худалдан авч,үүнээс 98 тн-ыг 102 аж ахуйн нэгж, малчдад тараан тэжээл үйлдвэрлэлийг дэмжсэн.

а)Доройтсон бэлчээрийг үет болон буурцагт ургамлын үр нэмэрлэн тарьж сайжруулах нь.

Доройтсон бэлчээрийг тэжээлийн олон наст ургамлын үр нэмэрлэн тарьж сайжруулах судалгааг туршилтыг 2004-2008 онд өндөр уулын бүслүүр(Их Тамир сум), ойт хээр (Шаамар сум), хээрийн бүс(Аргалант сум)-д явуулсан. Судалгааны дүнгээс үзэхэд: Үр нэмэрлэн тариалах технологиос мөрлөх арга нь хамгийн үр дүнтэй. Хур чийг элбэг, зуншлага сайтай жилүүдэд мөрлөх аргын зэрэгцээ үрээ цацаад малаар гишгүүлэх арга нь бусад аргаас илүү үр дүнтэй байв. Тарих хугацааны хувьд хавар болон зун тарих нь соёолсон ургамлын биежилтэд эерэг нөлөөтэй байхад тарьсан үрийн амьдралтад сөргөөр нөлөөлж буй нэг гол хүчин зүйл болох 7, 8 сарын агаарын халалтын улмаас хөрсний чийг 8.0 мм-ээс доош буурч, хөрсний температур 30° с-аас дээш гарсан тохиолдолд цухуйц хатаж үхэж байна. Туршлагын ажлын явц, үр дүнгээс үзэхэд: Бэлчээрийг нэгэнт талхалж доройтуулваас үр нэмэрлэн тарих аргаар нөхөн сэргээх асуудал Монголд орны нөхцөлд төвөгтэй, арга технологийн хувьд эрсдэл ихтэй, цаг хугацаа, хөрөнгө хүч их шаардах хүндрэлтэй ажил болохыг малчдад ойлгуулж, бэлчээрийг хэт доройтуулалгүйгээр зохистой ашиглахыг ухамсарлуулах нь зүйтэй байна.

Хэрэгжилт-70%

б)Доройтсон бэлчээрийн ургамлан нөмрөгийн мониторингийн судалгаа:

Өнгөрсөн 5 жилд доройтсон бэлчээрийг хашиж, малын хөлөөс чөлөөлөх замаар ургамлан нөмрөгийн сэргэлтийг дэмжих туршилт судалгааг 2004 оноос эхлэн ойт хээрийн бүс Сэлэнгэ аймгийн Шаамар суманд чийгэрхэг,алаг өвст-улаан толгойт, намгархаг алаг өвст-улалжит, хээржсэн алаг өвст-хиагт нугын бэлчээр, өндөр уулын бүслүүрийг төлөөлүүлэн Архангай аймгийн Их тамир суманд ботууль-алаг өвст хээрийн бага, дунд,хүчтэй доройтсон бэлчээрт явуулав. Бэлчээрийг ашиглалтаас 5 жилээр чөлөөлөхөд ургамлан нөмрөгийн бүрхэц тухайн бэлчээрийн хэв шинж болоод уур амьсгалын онцлогоос хамааран 12-82%-иар нэмэгдэн тогтворжиж байна. Ургамлын бүрхэц нэмэгдэхийг даган бэлчээрлэлтийн нөлөөгөөр доройтолд орсон зүйл ургамлууд сэргэн ургаж, бэлчээрийн зүйлийн бүрэлдэхүүн 17-54%-иар нэмэгдэжээБэлчээрийг 2-3 жил дараалан давтан ашиглахад татмын нугын бэлчээрийн ургац 19-46%, ботууль-алаг өвст бэлчээрийнх 10-34%, харин 4 удаа давтан ашиглахад бэлчээрийн ургац 43 хүртэл хувиар тус тус буурч байгаа нь жил дараалсан давтан ашиглалтын нөлөөгөөр бэлчээр эрс доройтдог болохыг харуулж байна. Харин бэлчээрийг 3 см-ийн өндрөөр 2-3

жил дараалан ашиглахад ургац бодитойгоор буурахгүй байгаагаас үзэхэд бэлчээрийг зохистой хэмжээгээр жил дараалан ашиглахад төдийлөн сөрөг нөлөөгүй болохыг харуулж байна.

Хэрэгжилт-80%

в)Бэлчээрт мал бэлчээрлэлтийн үзүүлэх нөлөөг судлах нь:

Ашиглалттай болон ашиглалтаас чөлөөлсөн бэлчээрийн харьцуулсан судалгааны дүнгээс үзэхэд: Мал бэлчээрлэлт нь бэлчээрийг доройтуулах үндсэн хүчин зүйл болж байна. Доройтсон бэлчээрийг ашиглалтаас урт, богино хугацаагаар чөлөөлөхөд ургамлын сэргэлт доройтлын түвшингээс хамааран харилцан адилгүй байв. Тухайлбал:

- Бага зэрэг доройтсон бэлчээрийн голлох зүйл ургамлууд устаагүй, доройтолд төдийлөн ороогүйгээс сэргэлт төдийлөн ажиглагддаггүй.
- Хэт доройтсон бэлчээрийн хувьд голлох зүйл ургамлууд устаж доройтсоноос ургамал сэргэх боломж харьцангуй бага тул мэдэгдэхүйц хэмжээний өөрчлөлт ажиглагддаггүй.
- Дунд зэргийн доройтолтой бэлчээрийг ашиглалтаас чөлөөлснөөр мэдэгдэхүйц сэргэлт гарч байна.

Ашиглалтаас чөлөөлсөн бэлчээрийн ургац ашиглалттай бэлчээртэй харьцуулахад доройтлын зэрэглэлээс хамааран 6-119 г/м² –аар нэмэгдэж, бэлчээрийн төлөв байдлын чанарын гол үзүүлэлт болох үетэн ургамлын эзлэх хувь бодитойгоор нэмэгдэж байна. Хэт доройтсон бэлчээрийг 5 жилээр өнжөөхөд бэлчээр чанарын хувьд сэргэх, үетэн ургамал сэргэн ургах боломж муу хэдий ч хээрийн бүсийн Агь шарилжит хэт их доройтсон бэлчээрт хялгана зэрэг үетэн ургамлууд шинээр бүртгэгдэж мөн хөрсний сүвшилт, ус нэвтрүүлэх чадварт эерэг өөрчлөлт гарч байгаа нь сэргэлт эхэлж буйг харуулж байна.

Хэрэгжилт-75%

г)Бэлчээрийн эрүүл мэндийн мониторинг:

АНУ-ын Нью Мехико мужийн Хорнадогийн Эрдэм шинжилгээний төвөөс боловсруулагдан АНУ, Австралид өргөнөөр хэрэглэгдэж байгаа цөлөрхөг болон хуурай бүс нутгийн бэлчээрийн мониторингийн хурдавчилсан арга зүйг өөрийн орны нөхцөлд турших хээрийн хамтарсан судалгаа зохион байгуулж, уг аргыг Монголд үндэсний хэмжээнд нэвтрүүлэх боломжийн талаар холбогдох мэргэжлийн байгууллагууд болон мэргэжилтнүүдийг хамарсан ярилцлага, хэлэлцүүлгийг хэд хэдэн удаа зохион байгуулснаар хурдавчилсан аргаар тодорхойлж болох үндсэн үзүүлэлтүүд дээр нэгдсэн ойлголтод хүрсэн. Хурдавчилсан арга зүйн гол давуу тал нь богино хугацаанд судалгааны олон цэгийг хамарч ажиллах боломжтойгоос гадна судлаачийн арга туршилагаас хамаарах алдаа гарах магадлал харьцангуй багатай байдагт оршино. Бэлчээрийн үндэсний мониторингийн сүлжээг бэхжүүлэхдээ улсын хэмжээнд мониторингийн 1550 цэгтэй, орон нутагт харьцангуй тогтворжсон сүлжээтэй УЦУОШГ-ын бааз суурийг бэхжүүлэх замаар ажиллах нь давхардлыг бууруулах, хөрөнгө хүч, цаг хугацаа хэмнэсэн хамгийн оновчтой зам болохыг

тодорхойлж дээрх газартай хамтран ажиллах гэрээ байгуулж, санамж бичиг үйлдэн, орон нутаг дахь техникчдийг сургах, зарим шаардлагатай багаж төхөөрөмжөөр хангах ажлыг эхлүүлжээ. Бэлчээрийн үндэсний мониторингийн системийг боловсронгуй болгох ажлын хүрээнд эхний ээлжинд Монгол орны экологийн бүсүүдийг төлөөлөх 10 аймгийн 15 сумын 70 цэгт мониторингийн нэгдсэн арга зүйг турших, Монголын нөхцөлд тохируулан нэвтрүүлэх, экологийн түлхүүр цэгийг тодорхойлох ерөнхий үзэл баримтлалыг боловсруулах хээрийн судалгааг 2009 оны зун зохитн байгуулсан.

Хэрэгжилт-78%

д)Хаягдсан тариалангийн талбайг нөхөн сэргээх:

2005-2008 онд ойт хээр(Төв аймгийн Баянчандмань, Борнуур), хээр(Төв аймгийн Аргалант)-ийн бүсэд хээрийн туршилт судалгаа явуулсан. Судалгааны явцад хаягдсан тариалангийн талбайг нөхөн сэргээх технологийн асуудлыг боловсронгуй болгох зорилгоор хөрс боловсруулалтын 2, тариалах техникийн 3, хог ургамалтай тэмцэх аргын 5 хувилбарыг туршсан байна. Хаягдсан талбайг нөхөн сэргээхэд эрлийз царгас, нумраа хунчир, хошоон хунчир, монгол ерхөг, соргүй согоовор, дагуур өлөнгө, сибирь хялганыг сонгож, 1 га-д 14.8-17.2 кг үрийн хольц тариалжээ. Олон наст ургамлыг тариалахад СКП-2.1(ОХУ), John Deere(АНУ), 9 MSB 2.1(ӨМӨЗО) үрлэгчүүдийг ашигласан.

Судалгаанаас үзэхэд:Хөрс боловсруулалтын болон тариалалтын ажлын технологийг нарийн мөрдөж ажиллавал атаришиж хаягдсан тариалангийн талбайг олон наст ургамал тариалж нөхөн сэргээх бүрэн боломжтой байна.Хаягдсан тариалангийн талбайн хөрсийг хавар хагалж боловсруулаад олон наст ургамлын үрийн хольцыг нэг наст ургамлын нөмөр дор СКП-2.1 үрлэгчээр тариалахад таримлын амьдрах ба өвөлжих чадвар сайн, хог ургамлын тархалт бага байх боломжтой байна.

Хэрэгжилт-72%

е)Тэжээлийн олон наст үет, буурцагт ургамлын төрөл, зүйл шалгаруулах:

Манай орны хуурай нөхцөлд зохицсон олон наст үет, буурцагт ургамлын төрөл, зүйлийн тоог олируулах, тэдгээрийн үрийн нөөцийг нэмэгдүүлэх зорилгоор нутгийн болон гадаадын тэжээлийн ач холбогдол өндөртэй олон наст үет ба буурцагт ургамлын зүйл сортыг аж ахуй, биологийн гол үзүүлэлтүүдээр сонгон шалгаруулах судалгааны ажлыг 2004-2008 онд ойт хээр ба хээрийн бүсэд явуулж нутгийн болон ОХУ, АНУ, ӨМӨЗО, Хятад, Исланд, Канадын нийт 35 зүйл ургамлын 50 сорт, дээжийг тарьж туршсан байна. Хээрийн бүсийн усалгаагүй нөхцөлд 2004-2008 онд 32 зүйл ургамлын 47 сорт, дээж судалгаанд хамрагдсанаас амьдрах ба өвөлжих чадвар, бутлалт, өвсний ба үрийн ургацаар нутгийн Сибирь Хялгана(*Stipa sibirica*) тарималжих, ӨМӨЗО-ны монгол ерхөг(*Agropyron mongolicum*) нутагиших боломжтойгоор шалгарав. Харин ойт хээрийн бүсийн усалгаагүй нөхцөлд 2005-2008 онд 31

зүйл ургамлын 44 сорт, дээжийг тариалж турисанаас нутгийн эрлийз Царгасны (*Medicago varia*) “Бургалтай” сорт, ӨМӨЗО-ны дагуур өлөнгө (*Elymus dahuricus*), ОХУ-ын эмзэг түрүүт өлөнгө (*Psathyrostachys juncea*) манай орны нөхцөлд өвөлжих үрийн ба өвсний ургац өгөх чадвараар бусад дээжүүдээс илүү байв. Ойт хээрийн ба хээрийн бүсэд эмзэг түрүүт өлөнгө, саман ерхөгийн дээжүүд хамгийн эрт буюу 4 дүгээр сарын сүүлчээр сэргэн ургаж байгаа нь хавар эртийн таримал бэлчээрт зориулан тариалахад тохиромжтойг харууллаа.

Хэрэгжилт 80%

ё)Тэжээлийн олон наст ургамлын үр үржүүлэг:

Хуурай, гандуу нөхцөлд зохицсон олон наст ургамлын үр үржүүлгийн талбайд хог ургамалтай тэмцэх аргыг сонгох судалгааг 2007-2008 онд ойт хээрийн бүс(Төв аймгийн Борнуур)-эд усалгаатай ба усалгаагүй нөхцөлд явуулж хог ургамлыг хадах, гараар зулгаах, гербицид цацах, таримал ургамлын мөр хооронд сийрүүлэлт хийх зэрэг аргыг туршижээ. Судалгаанаас үзэхэд: Олон наст ургамлын амьдралын эхний 2 жилд хог ургамлыг нь хадах ба гараар зулгааж устгах нь илүү үр дүнтэй байв. Мөн эрлийз царгас амьдралын 2 дахь жилээс хог ургамлаа өөрөө түрж ургах чадвартай нь тогтоогдлоо. Манай орны хуурай нөхцөлд зохицсон олон наст ургамлын үр үржүүлэх ажлыг тэжээлийн Ургамлын Үр Үржүүлэгчдийн Холбоогоор дамжуулан 2006 оноос эхлэн хэрэгжүүлж байгаа ба Төв аймгийн Борнуур сумын нутагт 74.2 га (усалгаатай 10 га, усалгаагүй 64.2 га)-д эрлийз царгас (“Бургалтай”, “Нутаг бэлчээр-2” сортууд), дагуур өлөнгө, сибирь хялгана, саман ерхөг, цөлийн ерхөг, эмзэг түрүүт өлөнгө, соргүй согоовор, тэсэг зэрэг ургамлыг тариалжээ. 2007-2009 онд нийт 2600 кг (үүнээс царгас 255.3 кг, согоовор 355 кг, дагуур өлөнгө 1562 кг, сибирь хялгана 350 кг, монгол ерхөг 32 кг) үр хураасан байна.

Хэрэгжилт-82%

ж)Ногоон тэжээл үйлдвэрлэл: Таримал ногоон тэжээл үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх зорилгоор 2007-2008 онд ойт хээрийн бүсийн (Төв аймгийн Борнуур сум) усалгаатай ба усалгаагүй нөхцөлд тэжээлийн нэг наст ургамлын төрөл, зүйл сонгох судалгааны ажлыг гүйцэтгэлээ. Судалгаанд ОХУ ба ӨМӨЗО-ы тэжээлийн нэг наст 9 зүйл ургамлын 13 сорт, дээж хамрагдсанаас наранцэцэгийн “Енисей” (ОХУ), эрдэнэшишийн “Дүн Лин Бай” (ӨМӨЗО), “ВНИИМК 279” (ОХУ) сортууд ургацаар илүү болох нь харагдлаа. Наранцэцэг, эрдэнэшиш, судан өвс, вандуйг усалгаатай нөхцөлд тариалахад усалгаагүй тариалснаас 1,4-3,0 дахин илүү ногоон масс хурааж авах боломж байна.

Усалгаагүй нөхцөлд тэжээлийн нэг наст ургамлыг тарих тохиромжтой хугацааг сонгох судалгааны ажлыг 2006-2008 онд өндөр уулын (Архангай аймгийн Ихтамир сум) ба ойт хээрийн (Төв аймгийн Баянчандмань, Борнуур сумд) бүсэд гүйцэтгэжээ. Судалгаанд тэжээлийн нэг наст 9 зүйл ургамлын 10 сорт, дээж хамрагдсан ба тэдгээрийг 6-р сарын 5-аас 7-р сарын 5 хүртэл 4 өөр хугацаанд тарьж туршижээ.

	<p>Үр дүн 1.3.-ийн хэрэгжилт:81,5%</p> <p>Үр дүн 1-ийн хэрэгжилт-83,0%</p>	<p>төхөөрөмж, эм урвалж нийлүүлж, МААЭШХ-ийн Тэжээл үнэлгээний лабораторийг иж бүрэн шинэчлэн байгуулж, орчин үеийн тоног төхөөрөмжөөр тоноглож, ажилтнуудыг чадавхижуулж ирлээ. Лабораторийн ажилтнууд энэ хугацаанд лабораторийн чанарын гарын авлага боловсруулан СХҮТ-ээс тэжээлд шинжилгээ хийх стандартыг боловсруулж гэрчилгээ авсан.</p> <p>УЦУОШГ:Бэлчээрийн үндэсний мониторингийн сүлжээг бэхжүүлэхэд хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурснаар УЦУОШГ-ын бэлчээрийн явуул судалгааны цэгүүдийн бүс нутгийн бэлчээрийн хэв шинжийг төлөөлөх чадварыг дээшлүүлэх, цуглуулсан тоон материалыг илүү үнэмшилтэй болгон чанаржуулах, судалгааны материалыг экологийн төлөв байдалтай холбон дүгнэх, түүнийгээ бодлого боловсруулагч нарт хүргэх боловсронгуй механизм бий болгох ажлын эхлэлийг тавиад байна.</p> <p>Эхний ээлжинд 10 аймгийн 15 сумын цаг уурын харуулыг бэлчээрийн мониторингийн арга зүй, бэлчээрийн ургамал таних, тодорхойлох чадвар олгох сургалтанд хамруулж шаардлагатай зарим багаж хэрэгслээр хангалаа.</p> <p>Судлаачдын чадавхийг дээшлүүлэх:Бэлчээр тэжээлийн салбарын залуу боловсон хүчнийг сургах, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, чадавхижуулах зорилгоор сургууль төгссөн 17 мэргэжилтнийг судлаачаар ажиллуулан, судалгааны арга зүйд сургах, гадаад хэлний мэдлэгийг нь дээшлүүлэх тал дээр анхаарч ажиллаж ирсэн. Төслийн хугацаанд суурин судалгааны цэгүүд дээр ХААИС, МУИС-ийн нийт 30 орчим оюутныг дадлагажигч оюутнаар ажиллууллаа. Судалгааны ажлын үр дүнгээр эдүгээ 8 судлаач магистрын зэргээ амжилттай хамгаалж, 3 судлаач магистр, 1 судлаач докторын сургалтанд тус тус суралцаж байна. Исландад “Газрын доройтлыг бууруулах” олон улсын сургалтанд 3 судлаач хамрагдаж, Нью Мехико мужийн Хорнадагийн ЭШ-ий төвд 5 хүн мэргэжил дээшлүүлсний зэрэгцээ англи хэлний урт, богино хугацааны сургалтанд гадаадад 7, дотоодод давхардсан тоогоор 30 гаруй судлаач хамрагдлаа.</p> <p style="text-align: right;">Хэрэгжилт-74%</p> <p>Тэжээлийн ургамлын үр үйлдвэрлэгчдийн холбоо:2004 онд “Ногоон Алт” хөтөлбөрийн дэмжлэгээр байгуулагдсан Тэжээлийн Ургамлын Үр Үйлдвэрлэгчдийн Холбоо нь 2005-2008 онд нийт 214,1 тн нэг наст, 20,5 тн олон наст ургамлын үрийн нөөц бүрдүүлж түүнээс 203,6 тн нэг наст, 14,9 тн олон наст ургамлын үрийг 170 гаруй аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд нийлүүлжээ. Энэ нь ойролцоогоор 1700 га (нэг наст 1100 га, олон наст 600 га)-д тариалах үрийн хэрэгцээ бөгөөд 2006-2008 онд улсын хэмжээгээр тариалсан нийт тэжээлийн ургамлын (14439.5 га) үрийн 10 гаруй хувийг хангасан гэж үзэж болно. Мал аж ахуй, газар тариалан эрхлэгчдийн тэжээлийн ургамал тариалах үйл ажиллагааг дэмжих зорилгоор ТУҮҮХ-оос 2005 онд нэг ба олон наст ургамлын үрийн үнийг 50-70% хямдруулж олгосон нь уналтад ороод байсан таримал тэжээл үйлдвэрлэлийн салбарыг сэргээхэд томоохон түлхэц</p>
--	--	---

		<p>болсон юм. Тус холбоо нь 2008 оны байдлаар 78,8 сая төгрөгийн үндсэн, 4,2 сая төгрөгийн эргэлтийн хөрөнгөтэйгээр олон наст ургамлын үр үржүүлэх үйл ажиллагаагаа явуулж байна. 2007 оноос Төв аймгийн Борнуур сумын нутагт 107 га хаягдсан тариалангийн талбайг хашиж хамгаалан тэжээлийн олон наст ургамлын үр үржүүлэх ажлыг гүйцэтгэж байна.</p> <p style="text-align: right;">Хэрэгжилт 89%</p>
	<p>Үр дүн 2.1. Бэлчээрийн хамтын удирдлагын төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх.</p>	<p>Үр дүн 2.1: Архангай аймгийн Ихтамир, Баян-Өлгий аймгийн Цэнгэл, Дундговь аймгийн Өлзийт, Төв аймгийн Өндөрширээт, Завхан аймгийн 23, Ховд аймгийн 10 сум нийт 37 суманд бэлчээрийн менежментийг малчдын оролцоо болон тэдний хамтын байгууллагад түшиглэн хэрэгжүүлэх ажлыг нэвтрүүлээд байна. Дээрх сумдад “Бэлчээрийн менежментийн холбоо” ТББ-37, бэлчээрийн менежментийг хэрэгжүүлэх анхан шатны байгууллага болох “Бэлчээр ашиглагчдын хэсэг” 508 байгуулагдаж, 5000 гаруй малчид нэгдээд байна. (улсын хэмжээнд 2858 бэлчээр ашиглагчдын хэсэг байгуулагдсан) Сумдын ТББ-ыг бэхжүүлэх, чадавхижуулах зорилгоор сургалт, арга зүйн зөвлөмж өгөх ажлыг үе шаттай зохион байгуулж байр, техник хэрэгсэл (ажлын байр, өрөө, мотоцикл, мотор, компьютер, хэвлэгч, зургийн аппарат)-ээр хангасан. БАХ-ийг бэхжүүлэх ажлын хүрээнд: “Дундын мөнгөн хуримтлал” бий болгож төлөвлөсөн ажил үйлчилгээндээ зарцуулдаг хяналт, удирдлагын тогтолцоог бүх сумдад нэвтрүүлж байна. 2004-2008 онд дундын сангийн хуримтлал 217 сая төгрөгт хүрч түүнээс зээлэнд 2000 орчим малчин өрх хамрагдсанаас 8960 хүн ашиг хүртсэн байна. Малчид, бэлчээр ашиглагчдын хэсгийн ахлагч орон нутгийн мэргэжилтэн, удирдлагуудыг чадавхижуулах зорилгоор бэлчээрийн менежментийн сургалтыг хөтөлбөрийн сум бүрт 4-7 удаа хийв.</p> <p>Бэлчээрийн асуудлыг бэлчээр ашиглагчдын хэсэг, сумын түвшинд төлөвлөх, хэлэлцүүлэн батлуулах, дэмжиж хэрэгжүүлэх ажлыг хөтөлбөрийн 37 сум болон улсын хэмжээнд нэвтрүүлэх ажлыг зохион байгуулсан нь 2007 онд 15 аймаг (нийт аймгийн 71%), 187 сум (нийт сумдын 56%), 2008 онд хоёр жилийн гүйцэтгэлээр 276 сум (82%), 19 аймаг (90%)-ийн гүйцэтгэлтэй байна. Хөтөлбөрийн 5 суманд 2004-2008 онд зун намрын 1,4 сая га бэлчээрийг сэлгэж хувиартай ашиглахад 1,2 сая хонин толгой мал хамруулсан нь бэлчээрийн талхагдлыг бууруулж, 2878 өрх, 11431 малчин өрх хамрагдсан байна. Өвлийн 981000 га, хаврын 61000 га, зуны 86000 га, намрын 1000 га бэлчээрийг 2005-2008 онд тус тус өнжсөөж амраасан байна. Үүнд 1865 өрх 7460 малчин хамрагджээ. 2004-2008 онд шинээр 21 гар худаг гаргасан, инженерийн хийцтэй худаг 12-ыг засварлах буюу шинээр гаргаснаар 13.3 мян.га бэлчээрийг шинээр ашиглах (177 өрхийн 82.1 мян.толгой мал бэлчих) боломжтой болсон. Хөтөлбөрийн сумдад 4850 га бэлчээрт услалтын систем байгуулсны үр дүнд бэлчээрийн га-ийн ургацын хэмжээ 2-10 дахин нэмэгдэж 5 жилд нийтдээ 4500 тн ургац хураан авч 1.0 тэрбум төгрөгийн орлого олжээ.</p> <p>Бэлчээр ашиглагчдын хэсгүүд дангаараа болон хамтран</p>

	<p>Үр дүн 2.2. Малын үүлдэр угсааг сайжруулах.</p>	<p>нийт 1800 гаруй га хадлангийн талбайг хашиж хамгаалснаас жилд дунджаар 2500 орчим тонн хадлан бэлтгэж байна. Мөн үүний зэрэгцээ бэлчээр их хэмжээгээр сүйтгэж байгаа үлийн цагаан оготно ихээр тархсан бэлчээрт 6010 ширхэг сарны суудал бэлтгэж байрлуулснаар 10.0 гаруй мянган га бэлчээрийн үлийн цагаан оготныг устгасан байна. Хөтөлбөрийн сумдын “Бэлчээрийн менежментийн холбоо” ТББ-ууд цаг хүндэрсэн нөхцөлд эрсдэл багатай давахад малчдад туслах зорилгоор, эрсдлийн санг арвижуулах үүднээс дунджаар жилд 5500 тн хадлан, тэжээлийн нөөц бүрдүүлж байна.</p> <p>ХХААХҮЯ-ны захиалгаар Завхан аймгийн Багахайрхан, Говь-Алтай аймгийн Бор-Аргалантын отрын бэлчээрийн бүтэц, бүрэлдэхүүн, нөөц, багтаамжийг тодорхойлж, үнэлгээ өгсөн. Хэнтий аймгийн Хэрлэнбаян-Улаанд өвөлжөө, хаваржааны байршил, ургамлын бүтэц бүрэлдэхүүн, мониторингийн цэг тодорхойлж холбогдох судалгаа, тайлан, зурган материалыг боловсруулж өгсөн байна.</p> <p>ХХААХҮЯ-ны аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын захиргаатай тэдний чадавхийг нэмэгдүүлэх, өвс тэжээлийн нөөц бүрдүүлэх, хашилт хамгаалалтыг сайжруулах, бэлчээрийн нөөц тогтоох, мониторинг хийхэд нь туслах зорилгоор 45.0 сая төгрөгийн гэрээ байгуулж Бор-Аргалантын отрын бүс нутагт услалтын тоног төрөөрөмж авахад 7.5 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлсэн байна.</p> <p style="text-align: right;">Хэрэгжилт-80%</p> <p>Үр дүн 2.2: 2009 оны 11 сарын байдлаар хөтөлбөр хэрэгжиж буй 5 суманд үржлийн цөм сүрэг бий болгох зорилгоор өсгөсөн нийт малын тоо 3366 хүрээд байгаагийн дотор нийт хээлтэгч мал 439, үүнээс хонь 293, ямаа 146 байна. Төл (хурга 2820, ишиг 64) 2884, төл малаас хээлтүүлэгчид шилжсэн хурга 48-ыг бойжуулаад байна. Ашиг шим сайтай хээлтүүлэгчийг өөр нутгаас авчирсан бөгөөд хээлтэгчийг нутгийн үүлдрийн малаас шилжж сонгож ашигласан болно. Ингэснээр цус сэлбэгдэж “Баяд” омгийн хуцнаас гарсан хурга намар нь нутгийн төлтэй харьцуулахад амьдын жин дунджаар 7,8 кг буюу 20,8%, “Үзэмчин”, “Барга”, “Хотонт” үүлдрийн хуцнаас гарсан хурганых 2,8-11 кг буюу 10,4-41,0% тус тус илүү байна. Жил бүр ашиг шим сайтай 5-20 хуц, 3-4 ухна үржүүлгэнд ашиглагдаж ирсэн бөгөөд хуцнаас төрсөн хурга нас бие гүйцэний дараа амьдын жин дунджаар 6-9 кг, ухнаас гарсан ишгэнээс авах ноолуур дунджаар 50 гр нэмэгдсэн гэсэн тооцоо гарчээ. Ингэхэд жил бүр хүлээж авсан төлөөс авах мах, ноолуураас нийт 40,0 гаруй сая төгрөгийн ашиг олсон байх тооцоо гарч байна.</p> <p>Төлийн булчин цайх өвчний эсрэг селений бэлдмэлээр Өндөрширээт сумын “Мөөрс”, “Бэрх”, “Сант”, “Уулын хаан” гэсэн Бэлчээр Ашиглагчдын Хэсэгт 10000 төл, Их Тамир суманд мөн 10000 төл малыг тарьж сэргийлэв. Сумдад цөм сүрэг бий болгох ажлын хүрээнд гарсан төлийн бүртгэлийг тодорхой маягтын дагуу хөтөлж</p>
--	---	--

		<p>байна. Цөм сүргийн төл хүлээн авалт дунджаар 82%-тай байна. Их Тамир сум нутгийн “Тамир” хонь, илүү нугаламт хонь, Говь-Алтайн улаан ямаа, Завхан, Увс аймгаас “Баяд” хуцыг, Өндөрширээт сум ямааны ноолуурын гарц сайтай цөм сүрэгтэй болох зорилгоор нутгийн 60 ямааг шилэлт хийн, Өлзийт сумаас 2 ухна авчирч үржилд тавьсан болно. Хэрэгжилт 90%</p>
	<p>Үр дүн 2.3. Малчдын орлого нэмэгдүүлэх. Үр дүн 2-ийн хэрэгжилт-83,3%</p>	<p>Үр дүн 2.3: Хөтөлбөрөөс МАА-н бүтээгдэхүүний өртөг нэмэгдэх үе шатыг боловсронгуй болгох, малчдад чанартай түүхий эд өндөр үнэтэй байдгийг ойлгуулах, МАА-н бус орлогын эх үүсвэрүүдийг бий болгох ажлуудыг шат дараалалтай хийж иржээ. Сарлагийн хөөврийг самнаж бэлтгэх ажлыг малчдад хэвиүүлснээр 1 кг самнасан хөөврийн үнэ 2006–2008 оны хооронд 5-9 дахин нэмэгдэж 500 төгрөг байснаа 3500-4000 төгрөг боллоо. Ноос ноолуурын том үйлдвэрүүд анхан шатны ялгалт хийгдсэн түүхий эдийг бөөнөөр авах сонирхолтой байдаг нь үйлдвэрийн зардлыг багасгаж малчдын орлогыг нэмэгдүүлж байна. Тухайлбал Монгол улсын бүх сарлагийн тал хувийг дээрх стандартын дагуу хөөврийг нь бэлтгэнэ гэж үзвэл малчдын орлого 2005 оныхтой харьцуулбал 60 саяас 420 сая болж 360 саяар нэмэгдэх боломжтой. 2008 онд Архангай аймгийн Их Тамир суманд “Сарлагийн хөөврийн мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв”-ийг байгуулан ашиглалтанд оруулсан. Тус цехэд утас ээрэхээс бусад бүх машинуудыг суурилуулсан бөгөөд 13 залуу ажлын байртай болсон. Сумдын ТББ-ын байгалийн хадлан бэлтгэлийн хэмжээ жилээс жилд нэмэгдэж тайлант хугацаанд 11,3 мянган тн (2 тэрбум) хадлан бэлтгэжээ.</p> <p>Ногоон тэжээл тариалах ажил Архангай аймгийн Их Тамир, Завхан аймгийн Тэлмэн сумдад 2006 оноос эхэлсэн бөгөөд 2009 оны байдлаар 9 сум хамрагдаж 135 га талбайд 40 сая төгрөгийн зардал гарган тариалалт хийж 54 сая төгрөгийн үнэ бүхий 215 тн ургац хураан авсан. Тэлмэн суманд ногоон тэжээл тариалахад шаардлагатай трактор, чиргүүл дүүжин машин, хөрс боловсруулах болон тарих, хураах техникийн паркийг 40 сая төгрөгөөр болон Өндөрширээт суманд өвс хадах иж бүрэн техникийн салааг 15 сая төгрөгөөр тус тус бүрдүүлсэн болно. Төслийн 3 суманд төмс, хүнсний ногоо 2.3 га-д 1.4 тн үр тариалж 5.5 тн 3,2 сая төгрөгийн үнэ бүхий ургац хурааж авсан нь 75 өрх 260 иргэнд үр ашгаа өгнө гэсэн тооцоо гарсан байна.Төв аймгийн Өндөрширээт суманд 2008 онд 7 сая төгрөгний өртөгтэй эсгийний цех байгуулсан. Үүний үр дүнд Сумын малчид хэрэгцээт эсгийгээ зах зээлийн үнээс 16%-20%-аар хямд худалдаж авах боломжтой болж тус цех ч анхны өртөгөө нөхөж чадсан байна. Завханы Тэлмэн суманд ашиглагдахаа больсон хуучин зоорийг 3,5 сая төгрөгөөр худалдан авч 2,3 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар сэргээн засварлаж 100 тн-ын багтаамж бүхий ашигтай талбайтай болгосноор өөрсдийн тариалсан төмс хүнсний ногоог хадгалж байна. Малчдын өөрөө удирдах байгууллагыг бэхжүүлэхийн тулд санхүүгийн нөөц эх үүсвэр бий болгох зорилгоор</p>

	<p>Үр дүн 3. Бэлчээр сайжруулах, бэлчээрийн хамтын менежментийг хэрэгжүүлэх хууль эрх зүйн таатай орчин бүрдүүлэх.</p>	<p>хэсгийн дундын мөнгөн хуримтлал бий болгох ажлыг бүх сумдад хэрэгжүүлээ. Эхний удаад хөтөлбөр болон БАХ хоёр талаасаа 50, 50 хувиар мөнгөн хөрөнгө нийлүүлж дундын мөнгөн хуримтлалыг бий болгож байгаа. Одоогийн байдлаар дундын сангийн нийт хэмжээ 5 сумын дүнгээр 256.0 сая төгрөгт хүрээд байгаа бөгөөд 2000 гаруй өрх дундын сангаа хамтран ашиглаж байна. Цэнгэл сумын “Малчны холбоо”-ноос санаачлан “Малчны хөгжил” олон талт хоршоо байгуулав. Холбооны 423 гишүүн ХЗХ-нд гишүүнээр элсэж бага хүүтэй зээл, өндөр хүүтэй хадгаламжийн үйлчилгээнд хамрагдсан. Мөн хөрөнгө оруулалтын чиглэлтэй үйлчилгээ үзүүлж, эргэж төлөгдөх нөхцөлтэйгээр хадлангийн талбай хаших, үйлдвэр үйлчилгээний салбар ажиллуулахад хөрөнгө оруулж байна. Хэсэг дундын тэжээлийн нөөц бүрдүүлж зуд гамшигийг өөрийн хүчээр даван туулах сан бүрдүүлэх ажил эхэлж байна.</p> <p style="text-align: right;">Хэрэгжилт-80%</p> <p>Үр дүн 3: Хөтөлбөрийн зүгээс, бэлчээрийн менежментийн эрхзүйн зохицуулалтыг боловсронгуй болгоход чиглэсэн хэд хэдэн арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэнээс:</p> <ul style="list-style-type: none"> -УИХ-ын Байгаль Орчин, Хүнс, Хөдөө Аж Ахуйн байнгын хороо (БОХХАА), Газрын Харилцаа, Геодези, Зураг Зүйн Газар (ГХГЗЗГ)- тай хамтран “Бэлчээрийн менежментийг боловсронгуй болгох онол, практикийн асуудал” сэдэвт үндэсний хэмжээний бага хурлыг 2006 онд зохион байгуулж, бодлого боловсруулагчид, эрдэмтэд, хөдөө орон нутгийн удирдлага, малчдын төлөөллийг оролцуулан Монгол орны бэлчээр ашиглалтын өнгөрсөн, одоо, хэтийн төлөв, цаашид авах арга хэмжээний талаар хэлэлцсэн. -Малчдын талаар төрөөс баримтлах бодлогын баримт бичигт малчдын өөрийгөө удирдах байгууллагыг чадавхжуулах, бэхжүүлэх асуудлаар санал боловсруулж тусгасан. -УИХ-ын Байгаль орчин, Хүнс, Хөдөө аж ахуйн Байнгын хороотой хамтран 2007 онд “Бэлчээрийн тухай хууль”-ийн төслийн хэлэлцүүлгийг нийт 6 аймагт зохион байгуулсан бөгөөд үүнд 67 сумын 354 малчид, холбогдох мэргэжилтнүүд оролцож, бэлчээрийн даац, доройтол, түүний шалтгаан, бэлчээрийг ямар хэлбэрээр эзэмшүүлэх, бэлчээрийн менежментийн эрхзүйн орчинг тодорхойлох зорилгоор социологийн судалгаа авч, санал солилцсон ба судалгаанд оролцогчдын 50-аас дээш хувь нь бэлчээр доройтсоны шалтгаан нь малын тоо бэлчээрийн даацаас хэтэрсэн, 44 хувь нь нутаг, ус ойролцоо байдаг хэд хэдэн өрх, хот айлаараа бэлчээрийг эзэмших нь дээр хэмээн хариулсан байна. -Монгол улсын “Газрын тухай” хуулинд өөрчлөлт оруулах ажлын хэсэгт орж ажиллан, газрын хуульд тусгагдсан бэлчээртэй холбогдох заалтуудыг практикт нийцүүлэх зорилгоор бэлчээрийн харилцааг тусгай хуулиар зохицуулах үндсэн саналыг дэвшүүлж, нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төсөлд бэлчээрийн эрхзүйн зохицуулалтыг боловсронгуй болгох талаар тодорхой саналыг өгсөн.
--	---	--

		<p>-“Бэлчээрийн тухай хууль”-ийн төслийг боловсруулж, түүнд, малчдын оролцоонд тулгаарлан бэлчээрийн нөөц, хилийг тогтоон нэгж талбаруудад хуваах, малчдын бэлчээр ашиглах болон эзэмших үйл ажиллагааг хамтын хэлбэрээр зохион байгуулах, бэлчээрийн даацад тохируулан малын тоо толгойг зохицуулан хязгаарлах, аймаг, сумын отрын бүс нутаг бий болгох, бэлчээрийг эзэмшүүлэх зэрэг тулгуур асуудлуудыг зохицуулахаар тусгасан болно.</p> <p>-Бэлчээрийн эрхзүйн зохицуулалтыг боловсронгуй болгох чиглэлээр нийт иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудыг мэдээллээр хангах, сурталчлах зорилгоор Монголын Үндэсний Олон Нийтийн радио телевизээр нэвтрүүлэг, уулзалт, шууд ярилцлага зохион байгуулж бэлчээрийн менежментийн туршилага, бэлчээрийг зүй зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх арга технологийн талаар мэдээлэл хийсэн нь газрын хуулийн бэлчээрийн харилцааны заалтын хэрэгжилт, бэлчээрийн талаар нийгэмд тулгарч буй асуудлыг шийдвэрлэх арга замыг тодорхойлоход чиглэсэн нийтэд хүртээмжтэй арга хэмжээ болов.</p> <p>-Хятадын ӨМӨЗОрны бэлчээрийн хуулийн хэрэгжилт, сургамж, туршилага судлах ажлыг зохион байгуулсан нь бэлчээрийн харилцааны эрхзүйн зохицуулалтын цаашидын хандлагыг оновчтой тодорхойлоход дөхөмтэй ажил болсон.</p> <p style="text-align: right;">Хэрэгжилт-75%</p>
<p>Үр дүн 4.1. Хөтөлбөрийн төлөвлөлт, зохион байгуулалт, мониторинг үнэлгээний чадавхийг бэхжүүлэх.</p>		<p>Үр дүн 4.1: Хөтөлбөрийн хүрээнд хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлсэн ба тайланг Удирдах Зөвлөлийн Хурлаар /УЗХ/ хэлэлцүүлэн, ХХААХҮЯ, ШХА болон сонирхогч бусад талуудад танилцуулдаг.</p> <p>Байгууллагын үйл ажиллагааны онцлогийг харгалзан, дотоод мэдээллийн сан үүсгэж, ангилал хийн, баяжуулсан ба энэ нь байнгын холбоотой ажилладаг ТББ, хөтөлбөр хэрэгжиж буй бусад газруудаас тайлан мэдээг цаг хугацаанд нь тогтмол, тогтсон загвараар авах, хоорондын шуурхай ажиллагааг хангах нөхцөл боломж бүрдэв. Өөрийн байгууллагын цахим мэдээллийн http://www.greengold.mn/ интернэт хаягтай болсноор, бэлчээр, ХАА-н чиглэлээр төр засгийн баримталж буй бодлого, авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, малчдын орлого нэмэгдүүлэх, бэлчээр сайжруулах арга технологи, хамтын ажиллагааны ололт, тулгарч буй хүндрэл, бэрхшээл, МАА-н бүтээгдэхүүний зах зээлийн байдал, үнэ хани зэрэг малчид болоод нийгмийн хэрэгцээт мэдээллийг түргэн шуурхай, үнэ төлбөргүй авч ашиглах боломжийг олгож байгаа юм. Мөн өөрийн дотоод нөөц бололцоонд тулгуурлан аудио, видео хичээл бэлтгэх, кино хийх мэргэжлийн түвшний жижиг студитэй болсон нь хөтөлбөрийн үр дүн, үйл ажиллагааг олон нийтэд мэдээлэх, малчдын орлого нэмэгдүүлэх, бэлчээр сайжруулах технологи нэвтрүүлэх, үр дүнтэй хамтран ажиллах зарчим зэрэг олон төрлийн сургалт болон сурталчилгааны кино хичээл, гарын авлага, танин мэдэхүйн бусад мэдээ мэдээллийг нэгтгэн, хүн бүрт ойлгомжтой, хүртээмжтэй хүргэх нөхцөл бүрдэж</p>

<p>Үр дүн 4.2 Хөтөлбөрийг дэмжих нэгжийн ажилтнуудын чадавхийг бэхжүүлэх.</p> <p>Үр дүн 4.3. Олон улсын зөвлөх, мэргэжилтнүүдтэй хамтран ажиллах.</p>	<p>байгаа нь оюуны хөрөнгө оруулалтын томоохон хэлбэрийн нэг болох юм. Тус студийн зүгээс 2007 онд 6 төрлийн кино хичээл, танилцуулга зэргийг бэлтгэн, нийтийн хүртээл болгосон болно.</p> <p style="text-align: right;">Хэрэгжилт 84%</p> <p>Үр дүн 4.2-: Хөтөлбөрийг Дэмжих Нэгж /ХДН/-ийн ажилтнууд болон хээрийн туршилт судалгаанд оролцдог бүх залуу судлаачдын гадаад хэлний мэдлэг болон мэргэшлийн ур чадварыг дээшлүүлэх зорилгоор дотоодод англи хэлний дамжаанд шатлан суралцуулах, гадаад орнуудад урт, богино хугацааны томилолтоор явуулах зэрэг ажлуудыг хийв. Үүнд:</p> <p>АНУ-ын Колорадогийн их сургуульд хамтын нийгэмлэгт түшиглэсэн бэлчээрийн болон газрын менежментийн чиглэлээр 1 хүн 3 сар, Исландын ХАА-н их сургуульд экологи, байгаль орчны үнэлгээ, газар зохион байгуулалтын чиглэлээр 1 хүн 6 сар, Непал улсад хамтын менежментийн чиглэлээр гарч буй дэвшил, харилцан туршилага солилцох орон нутгийн 2 ажилтан 11 хоногийн аялалд, 2 хүн Итали улсад, англи хэлний курсэд Сингапур улсад 1 хүн 3 сар, Филиппин улсад 1 хүн 3 сар тус тус мэргэшүүлсэн.</p> <p style="text-align: right;">Хэрэгжилт-81%</p> <p>Үр дүн 4.3: Тайлант хугацаанд судалгаа, хамтын нийгэмлэгийн менежментийн чиглэлээр олон улсын хэд хэдэн зөвлөхүүд ирж ажиллалаа. Судалгааны чиглэлээр Швейцарийн Агроскопоос профессор Ж.Ноесбергер доктор Андреас Лушер нар хээрийн туршилт, судалгааны ажлын арга зүй боловсруулах, мэдээлэл цуглуулах, туршилтын үр дүнг задлан шинжлэх, тайлбарлах, газар дээр нь зөвлөлгөө өгөх, эрдэм шинжилгээний тайлан өгүүлэл бичих талаар залуу судлаачдыг сургах зөвлөх чиглэлээр ажиллажээ.</p> <p>Нью Мехико мужийн Хорнадагийн ЭШТ-ийн судлаач доктор Жефф Херрик, Брендон Вейстелмайер нар Бэлчээрийн эрүүл мэндийн үнэлгээ, мониторингийн арга зүйг Монгол орны нөхцөлд туршин нэвтрүүлэх, тухайн чиглэлээр үндэсний чадавхийг бэхжүүлэхэд арга зүйн зөвлөлгөө өгч ажилладаг.</p> <p>Дээрх зөвлөхүүдийн хичээл зүтгэлээр Ногоон алт хөтөлбөрийн судалгааны ажлын үр дүнгээр бүтээл туурвих, олон улсын хэмжээний илтгэл өгүүлэл бичих замаар өөрсдийн үйл ажиллагааг дэлхийд таниулах, тэндээс суралцах талаар тодорхой түвшинд чадавхижиж буй илрэл бол 2009 оны Дэлхийн Бэлчээрийн их хуралд болон бүс нутгийн хурлуудаар 5 постерт илтгэл хэлэлцүүлсний зэрэгцээ Дэлхийн бэлчээрийн их хурлын 130 төлөөлөгч оролцсон аяллыг эх орондоо амжилттай зохион байгуулсан явдал мөн.</p> <p>Ханс П.Бинсвангер-Мхизе (2009) малчдын амьжиргааны түвшний судалгааны чиглэлээр доктор Пема Жамцо (2004-2008 он) хөтөлбөрийн төлөвлөлт, үйл ажиллагаа, хэрэгжилтийг үнэлэх, проф. Жозеп Ньосбергер, судлагаа технологийн багийнханд бэлчээрийн мониторинг, үнэлгээ хийх аргачлал, доктор Бахарат Покерелл (2008) хөтөлбөрийн сонгогдсон сумдын БАХ-ийн бүтэц, зохион байгуулалт, түүнд мониторинг хийх,</p>
--	--

**Үр дүн 4.4. ХХААХҮЯ,
ГХЗЗГ болон донор
төслүүдтэй хамтран
ажиллах.
Үр дүн4-ийн хэрэгжилт-
83,5%**

үйл ажиллагааг нь сайжруулах талаар зөвлөмж өгөх зорилгоор тус тус ажилласан байна.

Дээрх зөвлөхүүдийн ажлын дүнд Ногоон алт хөтөлбөрийн судалгааны ажлын үр дүнгээр бүтээл туурвих, олон улсын хэмжээний илтгэл өгүүлэл бичих замаар өөрсдийн үйл ажиллагааг дэлхийд таниулах, тэндээс суралцах талаар тодорхой түвшинд чадавхижиж буй илрэл бол 2009 оны Дэлхийн Бэлчээрийн их хуралд болон бүс нутгийн хурлуудаар 5 постерт илтгэл хэлэлцүүлсний зэрэгцээ Дэлхийн бэлчээрийн их хурлын 120 төлөөлөгч оролцсон аялалыг, эх орондоо амжилттай зохион байгуулсан явдал мөн.
Хэрэгжилт 84%

ХХААХҮЯ - Тус яамны сайд, Хөтөлбөрийн зохицуулагч нар 2007, 2009 онд төрийн зарим чиг үүргийг /бэлчээр, малчдын хамтын нийгэмлэг зэрэг/ хөтөлбөрөөр дамжуулан хэрэгжүүлэх чиглэлээр хамтран ажиллах тухай гэрээ байгуулж, санамж бичигт гарын үсэг зурав. Үүнд: бэлчээрийг урт хугацаанд зүй зохистой, тогтвортой ашиглах боломж, нөхцөл, менежментийн бодлогыг тодорхойлоход судалгаа, шинжилгээний ажлыг уялдуулах, бэлчээрийн менежментийн өнөөгийн чиг, хандлага, бэлчээрийн төлөв байдлын судалгаа, шинжилгээний ажлын үр дүн, шинэ технологи, малчдын тэргүүний арга барил, үүсгэл санаачлагыг сурталчлан нийтийн хүртээл болгох, бэлчээр судлалын эрдэмтэд, судлаачдын мэдлэг боловсрол, чадварыг дээшлүүлэхэд туслалцаа үзүүлэх зэрэг асуудлыг харилцан тохиролцов. Гэрээнд дурдсанаар малчдын хамтын нийгэмлэгт үндэслэсэн бэлчээрийн менежментийг бий болгож, төлөвшүүлэх, бэлчээрийг зохистой ашиглах, эзэмших, хамгаалахад чиглэгдсэн малчдын үйл ажиллагааг дэмжиж, тэдэнд арга зүй, менежментийн зөвлөгөө өгөх, малчдын хэсэг, бүлэг, нөхөрлөл, холбоодын үүсгэл санаачлагыг дэмжих, бэлчээрийн хамтын менежментийн төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх ажлыг орон нутгийн удирдлагатай хамтран зохион байгуулах чиглэлийг тусгасан болно. Мөн ХХААХҮЯ-ны харьяа аймаг дундын отрын бус нутгийн захиргаатай хамтран ажиллах гэрээг 2008-2009 онуудад байгуулан ажиллаж байна.

ГХБГЗЗГ – “Сумын газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөө боловсруулах аргачлал” арга зүйн зааврийг шинэчлэн боловсруулсан. ГХГЗЗГ-ын Газар зохион байгуулалтын хэлтэст бэлчээрийн асуудал хариуцсан мэргэжилтэн ажиллуулах, мөн 21 аймгийн газрын албадад бэлчээр хариуцсан орон тооны мэргэжилтэнүүдийг бий болгож УБ хотын ХААИС, ГХГЗЗГ болон Төв аймгийн Өндөрширээт суманд тус тус сургаж, дадлагажуулсан. Газар зохион байгуулалтын хэлтсийн мэргэжилтнүүдэд гадаад хэлний болон газар зүйн мэдээллийн системийн мэдлэг олгох, дадлагажуулах сургалтад тус тус 5 хүнийг хамруулсан. Бүх сумдын газрын даамлуудад дээрх арга зүйг эзэмшүүлэх ажлыг бүсчлэн зохион байгуулж хэрэгжилтыг хангуулах талаар болзолт уралдаан зарлах зэргээр үе шаттай арга хэмжээг хэрэгжүүлсэн болно.

		<p>Тухайн жилийн төлөвлөгөө боловсруулах ажлыг үр дүнтэй зохион байгуулсан Архангай, Хөвсгөл, Булган, Завхан аймгийн газрын албад болон сумдын даамлуудын ажлыг дэмжих зорилгоор 34 сая төгрөгийн урамшуулал олгосон. ГХГЗЗГ-ын Газар зохион байгуулалтын хэлтсийн үйл ажиллагааг бэхжүүлэх, техник тоног төхөөрөмжийг шинэчлэхэд тусалсан.</p> <p>ӨМӨЗО-ны Бэлчээр нутаг хайн байцаах, зураглан төлөвлөх хүрээлэн - Бэлчээрийн мониторингийн арга зүй боловсруулах, турших ажлын хүрээнд хамтын ажиллагааны санамж бичиг байгуулж, мэргэжилтэн солилцох, туршилага судлах, харилцан айлчлах зэрэг чиглэлээр хамтран ажиллаж байна.</p> <p>Бүх Хятадын Бэлчээр судлалын Шинжлэх Ухааны Академи-тай хамтран ажиллах санамж бичигт 2009 онд гарын үсэг зурсан.</p> <p style="text-align: right;">Хэрэгжилт 85%</p>
11	Дүгнэлт (ололт, дутагдал, анхаарах асуудлууд)	<p>Бэлчээрийн талхлалт, уул уурхайн олборлолт, автомашины замбараагүй хэрсэн замуудын улмаас бэлчээрийн бүтээмж, хөрсний бүрхүүл, биологийн төрөл зүйлд аюул учирч, зарим зүйлийн өвс, ургамал аажмаар устан үгүй болж, тэжээллэг чанар муутай сөөг, модлог ургамлаар солигдсоноос ургамлын бүрхүүл сийрэгжсэн. Энэ нь цаг агаарын өөрчлөлтөөс гадна бэлчээрийн нөөцийг буруу ашиглаж байгаа хүний үйл ажиллагаатай ихээхэн холбоотой юм.</p> <p>Бэлчээрийг өнжөөж, амраах, сэлгээх замаар сайжруулах нь Монголын нөхцөлд тохирсон арга гэдгийг туршилт, судалгаанууд нотоллоо.</p> <p>Бэлчээрийг нэгэнт талхалж доройтуулваас үр нэмэрлэн тарих аргаар нөхөн сэргээх асуудал манай орны нөхцөлд төвөгтэй, арга технологийн хувьд эрсдэл ихтэй, цаг хугацаа, хөрөнгө хүч их шаардах хүндрэлтэй ажил тул бэлчээрийг хэт доройтуулалгүйгээр зохистой ашиглах нь зүйтэй байна.</p> <p>Хөтөлбөр хэрэгжиж буй 5 сумдын малчид, орон нутгийн ТББ-ын ажилчид, засаг захиргааны ажилчид хамтран сумын бэлчээр зохион байгуулалт, хамтын менежментийн төлөвлөгөөг боловсруулж, амжилттай хэрэгжүүлж байна.Цаашид хэрэгжилтийн үр дүнг дүгнэх, нэгтгэх тал дээр талууд анхаарах, энэ чиглэлийн чадавхийг дээшлүүлэх сургалтыг “Ногоон алт” хөтөлбөрөөс явуулах шаардлагатай. Малчдаар бэлчээрт үнэлгээ хийлгэх ажлыг илүү үр дүнтэй, амжилттай хэрэгжүүлэхийн тулд малчдад давтан сургалт, талбайн сургалтуудыг зохион байгуулах, мөн малчдын хүүхдүүдийг хамруулан эко-бэлчээр сурагчдын бүлгийг байгуулж, тогтвортой үйл ажиллагааг дэмжин ажиллах шаардлагатай байна.</p> <p>Доктор Пуккараел Братын өгсөн зөвлөмжийн дагуу аливаа орлого нэмэгдүүлэх үйл ажиллагааг эхлэхийн өмнө тухайн бизнес болон үйлдвэрлэх бүтээгдэхүүний өртөг нэмэгдүүлэх анализыг урьдчилан хийх зайлигүй шаардлагатай байна. Мөн амьжиргааны түвшний анализыг хийснээр өрхүүдийн талаар суурь мэдээлэлтэй болох, нөгөө талаас хөтөлбөрөөс өрхийн орлого нэмэгдүүлэх чиглэлээр хийсэн үйл ажиллагаануудаас</p>

		<p>гарсан үр дүнг үнэлэх, хэмжих боломжгүй болох юм. Малчдын сэтгэлгээнд харьцангуй өөрчлөлт гарч байна. Тухайлбал, зөвхөн бэлчээрийн хамтын менежмент төдийгүй тухайн орон нутгийн хөгжлийн асуудлыг илүү сонирхох болжээ. Тэдний энэхүү хүсэл эрмэлзлэлд үндэслэсэн тухайн орон нутаг, сумын хөгжлийн стратегийн төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэхэд дэмжлэг туслалцаа үзүүлэх асуудал дутагдалтай байна. Санхүүжилтыг он тус бүрээр авч үзэхэд: 2004-2007 онуудад төсөвлөсөн хөрөнгийн 56.3-73.7%-ийг зарцуулсан нь төлөвлөлт бодитой бус, үндэслэлгүй хийгдсэнийг харуулж байна. Зарцуулсан хөрөнгийн 21%-ийг бэлчээр сайжруулах технологийг боловсронгуй болгоход, 64%-ийг бэлчээрийн хамтын менежментийг сайжруулахад зарцуулсан байна. Тайлангаас харахад үр нэмэрлэн тарих туршилтад ихээхэн зардлыг үргүй зарцуулжээ. Иймд цаашид усалгаатай нөхцөлийг ашиглах нь хөрөнгийн ашиглалтыг сайжруулахад чухал нөлөөтэй. Хөтөлбөрийн хэрэгжилтэд 83.3% буюу “Хангалттай” үнэлгээг өгч байна.</p>
12	Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч талуудын хамтын ажиллагаанд өгөх үнэлгээ	Хэрэгжүүлэгч талууд бололцоо, нөөцөө дайчлан хамтын ажиллагааг зохих түвшинд хэрэгжүүлж ажилласан байна.
13	Хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар өгөх зөвлөмж	<ol style="list-style-type: none"> 1. Хөтөлбөрийн хэрэгжилтийн дараагийн шатанд “Малчин малчнаасаа суралцах” боломжийг бий болгох, үзүүлэх сургалтуудыг зохион байгуулах. 2. Иргэд, малчдын оролцоон дээр үндэслэсэн газар, бэлчээрийн зохион байгуулалтын төлөвлөлт, түүнийг хэрэгжүүлэх асуудлыг боловсронгуй болгох. 3. Байгаль цаг уурын өөрчлөлт болон нүүдлийн мал аж ахуйн өнөөгийн практикт бэлчээрийг ашиглах, эзэмшүүлэх эрхийг нээхийн зэрэгцээ отрын болон нөөц бэлчээрийн эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох.